

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit@gmail.com](mailto:asaudit@gmail.com)  
Аудитор: Ц.Оюунтуул  
Утас: 99140953 Цахим хаяг: [asaudit.zul@gmail.com](mailto:asaudit.zul@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....	<b>Error! Bookmark not defined.</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН НЭГДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАХИРАЛ  
Х.АМАНГУЛ ТАНАА

2023.02.17 № 74  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

#### Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ байгууллагын онцлогт тохируулан батлах, хүнсний технологийн картыг баталж хэрэгжүүлэх.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,109,156.44	75,552,304.44
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	6,803,007.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	6,803,007.00
3121	Төгрөг	-	6,803,007.00
31211	Төрийн сангийн харилцах	-	6,803,007.00
33	АВЛАГА	15,000,000.00	-
335	Бусад авлага	15,000,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	15,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	63,109,156.44	68,749,297.44
354	Хангамжийн материал	63,109,156.44	68,749,297.44
35440	Түлш шатах тослох материал	6,525,000.00	10,000.00
35460	Хүнсний материал	5,831,728.00	4,231,719.00
35470	Бусад хангамжийн материал	50,752,428.44	64,507,578.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	809,106,836.68	820,616,053.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	809,106,836.68	820,616,053.97
392	Биет хөрөнгө	801,906,836.68	813,416,053.97
39201	Барилга, байгууламж	825,489,545.00	842,489,545.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(45,004,777.62)	(63,869,883.07)
39205	Машин, тоног төхөөрөмж	24,112,700.00	50,964,190.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,505,635.13)	(23,333,817.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,303,170.00	22,303,170.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,741,676.29)	(22,228,420.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,173,265.42	29,173,265.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,361,290.70)	(25,523,531.70)
39217	Номын фонд	3,441,536.00	3,441,536.00
393	Биет бус хөрөнгө	7,200,000.00	7,200,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хасагдуулга	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,200,000.00	7,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	887,215,993.12	896,168,358.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	887,215,993.12	896,168,358.41
51	Засгийн газрын хувь оролцоо	887,215,993.12	896,168,358.41
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	580,043,180.00	580,043,180.00
51101	Өмч: -Төрийн өмч	580,043,180.00	580,043,180.00
512	Хуримтлагдсан үр дүн	(9,441,117.76)	(488,752.47)
51210	Өмнөх үеийн үр дүн	(9,441,117.76)	(9,441,117.76)
51220	Тайлант үеийн үр дүн	-	8,952,365.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	316,613,930.88	316,613,930.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	887,215,993.12	896,168,358.41

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	566,999,424.00	717,404,240.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,524.00	37,362,340.00
120	Нийтлэг татварын бус орлого	155,524.00	37,362,340.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	155,524.00	37,362,340.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	155,524.00	37,362,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	40,652,400.00	680,041,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	618,220,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	618,220,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	526,191,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,000.00	103,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	205,000.00	103,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,447,400.00	61,718,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,447,400.00	61,718,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	571,570,491.05	708,451,874.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	571,570,491.05	708,451,874.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	550,507,141.05	708,451,785.71
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	402,169,800.00	479,826,674.00
210101	Цалин	367,403,600.00	394,046,586.00
210102	Нэмэгдэл цалин	-	76,207,800.00
210104	Урамшуулал	30,521,000.00	9,572,288.00
210105	Гэрээтийн цалин	4,245,200.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,293,000.00	63,051,600.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	54,293,000.00	42,875,100.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	5,044,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	4,035,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	1,008,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	10,088,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,097,600.00	34,908,100.00
210301	Гэрэл цахилгааны зардал	460,100.00	685,600.00
210302	Түлш, халаалтын зардал	33,568,000.00	34,097,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	69,500.00	125,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,111,344.00	103,500.00
210401	Бичиг хэргийн материал	250,000.00	103,500.00
210402	Тээвэр, шатахууны зардал	832,500.00	-
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	458,000.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	205,000.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,170,524.00	-
210408	Бараа материал актасны зардал	8,195,320.00	-
2105	Нормативт зардал	29,117,989.00	85,579,139.00
210501	Эм	111,600.00	-
210502	Хоол	28,241,389.00	85,579,139.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	765,000.00	-

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	210,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	558,000.00	-
210702	Дотоод томилолтын зардал	558,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	459,300.00	1,628,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	250,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	1,628,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,490,108.05	43,054,772.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,712,500.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,070,500.00	3,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,419,608.05	32,342,272.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,063,350.00	89.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,063,350.00	89.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,063,350.00	89.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(4,571,067.05)	8,952,365.29
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(4,571,067.05)	8,952,365.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	566,843,900.00	680,041,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,843,900.00	680,041,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	618,220,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	618,220,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	526,191,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,000.00	103,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	205,000.00	103,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,447,400.00	61,718,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,447,400.00	61,718,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	565,250,800.00	672,988,893.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	565,250,800.00	672,988,893.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544,187,450.00	672,988,804.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	402,169,800.00	479,826,674.00
210101	Үндсэн цалин	367,403,600.00	395,817,380.00
210102	Нэмэгдэл	-	76,207,800.00
210104	Үр дүнгийн урамшуулал	30,521,000.00	7,801,494.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,245,200.00	-
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	54,293,000.00	63,051,600.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	38,206,100.00	42,875,100.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,021,700.00	5,044,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,217,400.00	4,035,300.00

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	804,400.00	1,008,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,043,400.00	10,088,300.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	38,737,400.00	29,768,100.00
210301	Гэрэл цахилгааны зардал	460,100.00	685,600.00
210302	Түлш, халаалтын зардал	37,264,000.00	27,582,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,013,300.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,715,700.00	103,500.00
210401	Бичиг хэрэг	558,000.00	103,500.00
210402	Тээвэр, шатахуун	832,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	458,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	662,200.00	-
2105	Нормативт зардал	27,951,750.00	83,979,130.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111,600.00	-
210502	Хоол, хүнс	27,075,150.00	83,979,130.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	765,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,210,000.00	300,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	15,000,000.00	-
210604	Урсгал засвар	210,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	558,000.00	-
210702	Дотоод албан томилолт	558,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	459,300.00	1,628,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	209,300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,628,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,092,500.00	14,331,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,331,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	2,092,500.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,063,350.00	89.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,063,350.00	89.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,063,350.00	89.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,593,100.00	7,053,007.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,593,100.00	250,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,593,100.00	250,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,593,100.00	250,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,593,100.00	250,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,593,100.00)	(250,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	6,803,007.00

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,803,007.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511.00	51,300.00	51210+51220	
C01	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		-	-	-
C08	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	580,043,180.00	316,613,930.88	(9,441,117.76)	887,215,993.12
D01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	580,043,180.00	316,613,930.88	(9,441,117.76)	887,215,993.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	580,043,180.00	316,613,930.88	(9,441,117.76)	887,215,993.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	8,952,365.29	8,952,365.29
D09	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	580,043,180.00	316,613,930.88	(488,752.47)	896,168,358.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>679,938,400.00</b>	<b>673,238,804.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>679,938,400.00</b>	<b>673,238,804.00</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	679,938,400.00	673,238,804.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	483,152,300.00	479,826,674.00

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	399,143,000.00	395,817,380.00
210102	Нэмэгдэл	76,207,800.00	76,207,800.00
210104	Урамшуулал	7,801,500.00	7,801,494.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,051,600.00	63,051,600.00
210201	Тэтгэврийн даатгал	42,875,100.00	42,875,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,044,100.00	5,044,100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	4,035,300.00	4,035,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,008,800.00	1,008,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,088,300.00	10,088,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,768,100.00	29,768,100.00
210301	Гэрэл цахилгаан	1,973,400.00	685,600.00
210302	Түлш, халаалт	26,294,700.00	27,582,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	103,500.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	103,500.00
2105	Нормативт зардал	86,296,600.00	83,979,130.00
210502	Хоол, хүнс	86,296,600.00	83,979,130.00
2106	Эд хогшил худалдан авах	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,628,000.00	1,628,000.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,628,000.00	1,628,000.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	15,741,800.00	14,581,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,741,800.00	11,581,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	3,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>679,938,400.00</b>	<b>680,041,900.00</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	618,220,000.00	618,220,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	618,220,000.00	618,220,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,718,400.00	61,718,311.00
132001	Орон нутгийн төсвөөс	61,718,400.00	61,718,311.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	103,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	103,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,803,007.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	518,047,327.00	30.00
620001	Удирдах ажилтан	518,047,300.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	13.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/</b>	-	-
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГЭСЭДИЙН ТОО</b>	-	-

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	17.00	17.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	17.00	17.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Нэмэлт төсөв аваагүй

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>103,500.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>103,500.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	103,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	103,500.00
210401	Бичиг хэрэг		103,500.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	103,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	103,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		103,500.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Хүүхдийн нас сэтгэл зүйн онцлогт тохируулан багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоогоор хүүхдэд ЭЭЛТЭЙ СУРГАЛТЫН ОРЧИН бүрдүүлж, тэдний хүсэл сонирхлыг эрхэмлэн тоглонгоо хөгжүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд суурилан багшийн болон сургуулийн төлөвлөгөөг чанартай боловсруулж, гүйцэтгэлд суурилсан үнэлгээг цэцэрлэгт нэвтрүүлэх
- Багш бүр бүлгээр, багаар хамтран ажиллах нөхцөлийг цэцэрлэг бүр “мэргэжлийн баг” үүсгэж ажиллах.
- Хүүхэд эрүүл бие, бялдартай, биеийн хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд идэвх сонирхолтой оролцож, болзошгүй осол гэмтлээс сэргийлэх, эрүүл амьдрах дадалтай болох.
- Хүүхэд өөрийн болон хүмүүсийн сэтгэл хөдлөл, зан байдлыг танин мэдэх, ойлгох, сэтгэлийн хөдөлгөөн, зан, үйл, харилцаагаа эергээр зохицуулах хүмүүстэй хүндэтгэлтэй харилцах.
- Хүүхэд өөртөө итгэлтэй, эерэг зан чанартай, тууштай, суралцах сонирхолтой байх.
- Хүүхэд хүмүүсийг сонсож, тэдэнтэй ярилцаж мэдээлэл солилцох дуртай, санаа бодол, мэдрэмж, мэдлэг төсөөллөө хэл яриагаар илэрхийлэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт тэгш хамруулан сургах, хамрагдалтыг нэмэгдүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын тухай хууль, сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн захирлын 2021 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн А-08 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28.2 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	-	6.803.0	6.803.0
<b>Авлага</b>	15.000.0	-	-
<b>Бараа материал</b>	63.109.2	68.749.3	5.640.1
<b>Үндсэн хөрөнгө</b>	809.106.8	820.616.0	11.509.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>887.215.9</b>	<b>896.168.4</b>	<b>8.952.5</b>
<b>Өр төлбөр</b>	-	-	-
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	887.215.9	896.168.4	8.952.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>887.215.9</b>	<b>896.168.4</b>	<b>8.952.5</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 6.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс үндсэн цалингийн зардал хэмнэснээс үүдэлтэй бөгөөд үндсэн цалингийн хэмнэлтээс 3.3 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 48.5 хувийг, хоол хүнсний зардлаас 2.3 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 33.8хувийг, бараа үйлчилгээний бусад зардлаас 1.1 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 16.1 хувийг эзэлж байна.

Авлага нь оны эхэнд 15.0 сая төгрөгийн авлагатай байсныг авч, оны эцэст авлага үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс 8.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 15.2 сая, бусад эх үүсвэрээс 28.6 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 32.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 875.2 сая, орон нутгийн төсвөөс 61.7 сая, нийт зарлагыг 936.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 195.2 сая төгрөгөөр бууруулж 741,7 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарлалтад өөрчлөлт орсон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 680.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 61.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нэмэлт санхүүжилт 0.1 сая төгрөгийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 680.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 61.7 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилт 0.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 734.9 сая төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 3.3 сая төгрөгөөр, хоол хүнсний зардлын төсвийг 2.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлаас 1.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	546,203,900	542,878,274	3,325,626	99%
2	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	15,741,800	14,581,800	1,160,000	93%
3	Эрүүл мэндийн арга хэмжээ	2,200,000	2,200,000	-	100%
4	Боловсролын арга хэмжээ			-	
5	Үдийн цай хөтөлбөр	86,128,100	83,707,230	2,420,870	97%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин			-	
7	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх			-	
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	29,768,100	29,768,100	-	100%
	<b>Дүн</b>	<b>680,041,900</b>	<b>673,135,404</b>	<b>6,906,496</b>	<b>99%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэг 2022 онд 0.1 сая төгрөгийн нэмэлт төсөв авч зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Ц.Оюунтуул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 571.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 % байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгт завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 1.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 0.5 сая төгрөгийн 1 акт, 92.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	566.3	1	566.3	100%
Албан шаардлага	1	1,227.4	1	1,227.4	100%
Зөвлөмж	2	92,057.1	2	92,057.1	100%
Нийт дүн	4	93,850.8	4	93,850.8	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ байгууллагын онцлогт тохируулан батлах, хүнсний технологийн картыг баталж хэрэгжүүлэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1.Цэцэрлэгийн эрхлэгч нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10/9 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт” -ийн дагуу эрхлэгчийн ур чадварыг үнэлж дүгнээгүй байхад Сумын Засаг даргын 2021 оны А/48 дугаар захирамжийг үндэслэн 1.5 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл авсныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шалгуур	1	1.517.0	1	1.517.0									

Дэлүүн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үзүүлэлт хангаагүй ур чадварын нэмэгдэл авсан												
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1.517.0</b>	<b>1</b>	<b>1.517.0</b>								

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>									